



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/53

Хөхөө

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээрийн зүйлийн 59.1.11 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Эх үрсийн баяр”-ыг угтан Хөвсгөл аймаг 2024 оныг “Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих” жил болгон зарласантай холбогдуулан аймгийн Засаг даргын санал санаачилгыг дэмжин ажиллах хэрэгжилтийг хангуулан ажиллах, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн сайдын 2024 оны 03 дуаар сарын 20ны өдрийн А/149 дүгээр тушаалаар батлагдсан “Хүнсний аюулгүй байдал” арга хэмжээний хүрээнд хоол, хүнс үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн эрүүл ахуй, халдвар хамгаалалын дэглэм сахиулах бүтээгдэхүүн үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт, шалгалт хийх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Насанжаргал (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Гишүүд: М.Буяннэмэх (Хэсгийн төлөөлөгч)

Т.Алтанчимэг (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Ц.Нарангэрэл (Нийгмийн эрүүл мэндийн ажилтан)

Г.Чулуунбаатар (Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
нарийн бичгийн дарга)

Б.Золзаяа (Ерөнхий боловсролын сургуулийн хоол
зүйч)

Ө.Золзаяа - Хүүхдийн цэцэрлэгийн эмч

2. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн сайдын 2024 оны 03 дуаар сарын 20ны өдрийн А/149 дүгээр тушаалаар батлагдсан “Хүнсний аюулгүй байдал” арга хэмжээний чиглэлийн дагуу хүнсний чанар аюулгүй байдлын шаардлага

хангаагүй хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах, худалдаалах зөрчил илэрсэн тохиолдолд газар дээр нь зөрчлийг арилгах арга хэмжээ авах хоол үйлдвэрлэл үйлчилгээний ажлын байрны нөхцөл , хоол хүнсний аюулгүй байдлыг хангуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Насанжаргал)-д даалгасугай.

ДАРГА  Л.ЭНХЖАРГАЛ